



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 29 (362)

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ:

- *Журам батлах тухай*
- *Бөхчүүдэд улсын цол олгох тухай*

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ:

- *Журам батлах тухай*

Улсын Их Хурлын Тамгын газар

Улаанбаатар хот

2004 он



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ
Долоо хоног тутмын

Улаанбаатар хот

2004 оны долдугаар сарын 26

№29 (362)

Гарчиг

Нэг. МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

327.	Бөхчүүдэд улсын гарьд цол олгох тухай	Дугаар 101	659
328.	Улсын Их Хурлын анхдугаар чуулганыг товлон зарлах тухай	Дугаар 115	660
329.	АНУ-ын иргэн Жеймс Вагенландер, Алисиа Кемпи нарыг "Найрамдал" медалиар шагнах тухай	Дугаар 116	660
330.	Журам батлах тухай	Дугаар 126	660

Хоёр. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

331.	Журам батлах тухай	Дугаар 111	661
------	--------------------	------------	-----

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2004 оны 6 дугаар сарын 22 -ны өдөр

Дугаар 101

Улаанбаатар хот

Бөхчүүдэд улсын гарьд цол олгох тухай

Үндэсний их баяр наадмын тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 1 дүгээр зүйл, Үндэсний их баяр наадмыг зохион байгуулах хорооны саналыг үндэслэн ЗАРЛИГ болгох нь:

Үндэсний их баяр наадамд найм давсан дор дурдсан бөхчүүдэд улсын гарьд цол олгосугай.

1. Дамдингийн Баяраа
Хөвсгөл аймгийн Цагаан-Үүр сумын харьяат, "Алдар" спорт хорооны бөх

2. Пунцагийн Сүхбат
Баянхонгор аймгийн Баян-Овоо сумын харьяат, Нийслэлийн Баянгол дүүргийн Спорт сургалтын төвийн бөх

3. Цэдэндамбын Цэрэнпунцаг
Завхан аймгийн Цагаанчулуут сумын харьяат, "Хангарьд" дэвжээний бөх

4. Баянмөнхийн Гантогтох
Увс аймгийн Хяргас сумын харьяат, "Монгол газар" дэвжээний бөх

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ

1. САГАБАНДИ



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2004 оны 7 дугаар сарын 08 -ны өдөр

Дугаар 115

Улаанбаатар хот

Улсын Их Хурлын анхдугаар чуулганыг товлон зарлах тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн хорин долдугаар зүйлийн 4 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийг баримтлан Монгол Улсын Их Хурлын дөрөв дэх удаагийн сонгуулийн анхдугаар чуулганыг 2004 оны 7 дугаар

сарын 9-ний өдрийн 11.00 цагт Улаанбаатар хотноо хуралдуулж эхлэхээр товлон зарласугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н. БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2004 оны 7 дугаар сарын 08 -ны өдөр

Дугаар 116

Улаанбаатар хот

АНУ-ын иргэн Жеймс Вагенландер, Алисиа Кемпи нарыг "Найрамдал" медалиар шагнах тухай

Монгол Улс, Америкийн Нэгдсэн Улсын хоёр талын харилцааг урагшлуулж, ард түмний харилцан ойлголцлыг бэхжүүлэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж Монгол Улсаас АНУ-ын Денвер хотод суугаа Өргөмжит Консул Жеймс Вагенландер, АНУ-ын "Монголын нийгэмлэг"-ийн захирлын зөвлөлийн гишүүн, монголч эрдэмтэн

Алисиа Кемпи нарыг "Найрамдал" медалиар тус тус шагнасугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н. БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2004 оны 7 дугаар сарын 20 -ны өдөр

Дугаар 126

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Дипломат албаны тухай Монгол Улсын хуулийн 9 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасныг үндэслэн ЗАРЛИГ болгох нь:

2. Энэхүү зарлигийг 2004 оны 8 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

1. "Дипломат ажилтны тангараг өргөх журам"-ыг хавсралтын ёсоор баталсугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.БАГАБАНДИ

*Монгол Улсын Ерөнхийлөгчийн
126 дугаар зарлигийн хавсралт*

ДИПЛОМАТ АЖИЛТНЫ ТАНГАРАГ ӨРГӨХ ЖУРАМ

1. Монгол Улсын иргэн дипломат албан тушаалд томилогдохдоо Дипломат ажилтны тангараг /цаашид "тангараг" гэх/-ийг ёс төртэйгээр өргөнө.

тушаалд томилогдож буй ажилтныг шууд захиран удирдах албан тушаалтан байлцах бөгөөд холбогдох бусад ажилтнуудыг оролцуулж болно.

2. Тангараг өргөх ёслолыг гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын төрийн захиргааны удирдлагын газрын дарга, эсхүл эзгүйд нь түүнийг орлох албан тушаалтан тангараг өргөх өдөр, цагийг гадаад хэргийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнтэй тохиролцон товлож, тангараг өргөх ёслолын ажиллагааны бэлтгэлийг хангана.

4. Тангараг өргөх байрыг ёслол төгөлдөр тусгайлан бэлтгэж Монгол Улсын төрийн сүлд, төрийн далбааг хүндэтгэлтэйгээр байрлуулна.

5. Тангараг өргөх иргэн тогтоосон цагт тусгайлан бэлтгэсэн байранд хүндэтгэлтэйгээр орж Монгол Улсын төрийн сүлд рүү харан цэх зогсоно.

3. Тангараг өргөх ёслолын ажиллагаанд Сайдын зөвлөлийн гишүүд, дипломат албан

6. Тангараг өргөх ёслолын ажиллагааг хүний нөөцийн асуудал эрхэлсэн нэгжийн дарга буюу түүний томилсон албан тушаалтан удирдана.



Тангараг өргөх ёслолын ажиллагааг удирдаж байгаа албан тушаалтан тангараг өргөх ёслолын ажиллагааг нээж, дипломат албанд шинээр томилогдож буй хүмүүсийг танилцуулан хэвлэмэл тангаргийн бичгийг тангараг өргөгч бүрт гардуулна.

7. Тангаргийг хамтаар буюу ганцаар өргөж болох бөгөөд хамтаар өргөхөд хамгийн ахмад нь Дипломат ажилтны тангаргийг дээдлэн дуудаж бусад нь дагалдана. Тангараг өргөж байх үед уг ёслолд оролцогчид босч хүндэтгэнэ.

8. Тангаргийг дээдлэн дуудсаны дараа тангараг өргөгч нүүрэн талдаа Монгол Улсын төрийн сүлдтэй, түүний дор "Монгол Улсын дипломат ажилтны тангараг" гэсэн үгтэй, дотор талдаа Дипломат албаны тухай Монгол Улсын хуулийн 9 дүгээр үйлийн 2 дахь хэсэгт заасан тангаргийн бүрэн бичвэр бүхий тангаргийн бичигт тангараг өргөсөн он, сар, өдөр, овог, эцгийн нэр, нэрээ бичиж гарын үсэг зурна.

9. Гарын үсэг зурсны дараа тангаргийн бичгийг гадаад хэргийн асуудал эрхэлсэн Засгийн

газрын гишүүнд өргөн барина.

10. Тангараг өргөгч Монгол Улсын төрийн сүлдэнд мэхийн ёслож, зүүн өвдөг сөхрөн Монгол Улсын төрийн далбаанаас адис авна. Дараа нь Монгол Улсын төрийн дуулал эгшиглэнэ.

11. Тангараг өргөгчдөд хандаж гадаад хэргийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн баяр хүргэж товч үг хэлсний дараа тангараг өргөх ёслолын ажиллагааг удирдаж буй албан тушаалтан ёслолын ажиллагааг хаана.

12. Тангаргийн бичгийг тухайн албан хаагчийн хувийн хэрэгт хадгална.

13. Тангараг өргөх ёслолын ажиллагааны талаар тодорхой тэмдэглэл хөтөлнө.

14. Дипломат ажилтан төрийн үйлчилгээний-хээс бусад төрийн албан тушаалд шилжин ажилласны дараа дипломат албан тушаалд дахин томилогдвол тангараг өргөхгүй.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2004 оны 5 дугаар сарын 5 –ны өдөр

Дугаар 111

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Төрийн албаны тухай хуулийн 21.2-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1995 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн 215 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

Н.ЭНХБАЯР

**МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗРЫН
ДАРГА**

Ө.ЭНХТҮВШИН

1. "Төрийн жинхэнэ албан хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэх журам"-ыг хавсралт ёсоор баталсугай.

2. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Журам, жагсаалт батлах тухай" Засгийн газрын

Засгийн газрын 2004 оны

111 дүгээр тогтоолын хавсралт

ТӨРИЙН ЖИНХЭНЭ АЛБАН ХААГЧИЙН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг зүйл

1. Төрийн жинхэнэ албан хаагчийг түр хугацаагаар эзгүй байх үед түүний албан үүргийг хэвийн хэмжээнд хэрэгжүүлэх нөхцөлийг хангахад энэ журмын зорилго оршино.

Хоёр. Албан үүргийг түр орлон гүйцэтгэх нөхцөл

2. Төрийн жинхэнэ албаны дор дурдсан албан тушаалыг түр орлон гүйцэтгэнэ:

2.1. яамны Төрийн нарийн бичгийн дарга, газар, хэлтэс, түүнтэй адилтгах зохион байгуулалтын бүтцийн нэгжийн дарга;

2.2. Засгийн газрын агентлагийн дарга (хэрэв албан ёсны орлогчгүй бол), зохион байгуулалтын бүтцийн нэгжийн дарга;

2.3. аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын Тамгын газрын дарга, тухайн Тамгын газрын хэлтсийн дарга;

2.4. Ерөнхийлөгчийн Тамгын газар, Улсын Их Хурлын Тамгын газар, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Үндсэн хуулийн цэц, Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, шүүх, прокурорын төсвийн ерөнхий менежер болон Улсын Их Хуралд ажлаа тайлагнадаг байгууллагын ерөнхий менежерийн үүрэг гүйцэтгэдэг албан тушаалтан, эдгээр байгууллагын газар, хэлтэс, түүнтэй адилтгах зохион байгуулалтын нэгжийн дарга;

2.5. Улсын болон орон нутгийн төсвийн байгууллагын ерөнхий менежерийн үүрэг гүйцэтгэдэг (төрийн жинхэнэ албан хаагч) албан тушаалтан;

2.6. Тэдгээртэй адилтгах албан тушаал.

3. Дор дурдсан тохиолдолд энэ журмын 2-т заасан төрийн жинхэнэ албан хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгүүлнэ:

3.1. ээлжийн амралт эдлэх;

3.2. 1-3 сар хүртэл хугацааны сургалтад хамрагдах;

3.3. хууль тогтоомжид заасны дагуу тусгай чөлөө эдлэх, албан томилолтоор ажиллах;

3.4. удирдах дээд байгууллагын шийдвэрээр тусгай даалгавар, ажил, үүрэг гүйцэтгэх.

4. Төрийн албан хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэх тохиолдолд тухайн төрийн байгууллагын эрх бүхий албан тушаалтан түр орлон гүйцэтгэх ажилтантай тохиролцож, албан үүргээ орлуулах албан тушаалтны саналыг харгалзан албан үүргийг түр орлон гүйцэтгэх тухай шийдвэр гаргана. Төсвийн ерөнхий менежерийн үүрэг гүйцэтгэдэг албан хаагчийн хувьд төсвийн ерөнхийлөн захирагч шийдвэр гаргана. Шийдвэрт түр орлох хугацааг тодорхой заасан байна.

5. Албан тушаалтны албан үүргийг түр орлуулахдаа тухайн албан тушаалын дараагийн ангилал, зэрэглэлийн аль нэг албан тушаалын ажилтнаар түр орлуулна.

Гурав. Бусад зүйл

6. Албан үүргийг түр орлон гүйцэтгэсэн ажилтанд ийнхүү орлон гүйцэтгэсэн хугацааны албан тушаалын цалингийн зөрүүг олгоно. Хэрэв албан ёсны орлогч нь түр орлон ажилласан тохиолдолд албан тушаалын цалингийн зөрүү олгохгүй.

7. Энэ журмын 2-т зааснаас бусад албан тушаалтан энэхүү журмын 3-т заасан шалтгаанаар эзгүй байх үед тухайн байгууллагын дотоод журам, ажлын байрны тодорхойлолт (ажил, үүргийн хуваарь)-ыг үндэслэн түүнтэй адил ангилал, зэрэглэлийн аль нэг албан тушаалтанд ажлыг нь түр орлуулна. Энэ тохиолдолд түр орлон ажилласны цалингийн зөрүүг тусгайлан олгохгүй бөгөөд тухайн ажилтны үйл ажиллагааны үр дүн (үр дүнгийн гэрээний биелэлт), мэргэшлийн түвшинг үнэлэхдээ харгалзан үзэж, хууль тогтоомжид заасны дагуу урамшуулал олгоно.

8. Албан үүргийг түр орлон гүйцэтгүүлэх тухай төрийн байгууллагын эрх бүхий албан тушаалтан болон төсвийн ерөнхийлөн захирагчийн шийдвэр гарсны дараа уг албан үүргийг орлон гүйцэтгэх ажилтанд ажлыг албан ёсоор хүлээлгэн өгч, мөн орлон гүйцэтгэх хугацаа дууссаны дараа албан ёсоор хүлээн авна.

9. Албан үүрэг орлон гүйцэтгэгч нь тухайн ажлыг орлон гүйцэтгэх хугацаандаа бүрэн хариуцах бөгөөд төрийн байгууллагын эрх бүхий албан тушаалтан болон төсвийн ерөнхийлөн захирагчийн шийдвэрт өөрөөр заагаагүй бол үндсэн ажлаа нэгэн адил хариуцна.

10. Албан үүргийг түр орлон гүйцэтгэсэн ажилтанд олгох албан тушаалын цалингийн зөрүүг тухайн байгууллагын цалингийн сангаас гаргана.